

Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан

5.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/154 дүгээр тушаалын 13 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам”-ыг үндэслэн 2022.01.05-ны өдрийн 01 тоотой “МТЗ” ТӨХК-ийн 30 хагас вагонд, 03 тоотой “УБТЗ” ХНН-ийн харьяа Улаанбаатар татах хэсгийн гол замын ачааны 2ТЭ25КМ серийн 4 илчит тэргэнд, 04 тоотой тус байгууллагын сэлгээний ТЭМ18ДМ серийн 3 илчит тэргэнд, 06 тоотой “Монголиан транс ложистик” ХХК-ийн чингэлэг тээврийн зориулалтаар өөрчлөн тоногдсон 100 вагонд шинээр дугаар олгож, 2022.02.22-ны 64 тоотой “Илинк Жэй Ви ложистик” ХХК -ийн 200 тавцант вагонд, 65 тоотой “Монголиантранс лордс” ХХК-ийн худалдаж авч буй 300 хагас вагонд, 02.24-ний 68 тоотой “Баясон ложистик” ХХК-ийн 100 тавцант вагонд шинээр дугаар олгож, 02.09-ний 40 тоотой “Талын хишиг транс” ХХК-ийн түрээсийн 50 тавцант вагоныг, 02.10-ны 41 тоотой “Монголын төмөр зам” ТӨХК-ийн худалдаж авсан 30 хагас вагоныг, 2022.01.05-ны 07 тоотой “Эвт-Аян” ХХК-ийн түрээсийн 88 чингэлэг, 2022.02.22-ний 66 тоотой 1855 чингэлгийг төвийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

2022.01.019-ний өдрийн 21 тоотой “Вагон Импекс” ХХК-д эзэмшигч түрээслэгчийн “Т16” кодыг болон чингэлэг тээврийн 27 тавцант вагоныг, 22 тоотой “Үндэсний тээврийн корпораци” ХХК-ийн түрээсийн 150 тавцант вагоныг, 23 тоотой “Шууд хур” ХХК-д өмчлөгчийн “18” кодыг шинээр олгож 100 тавцант вагоны дугаарыг баталгаажуулан, 2022.03.09-ний 88 тоотой “Эйр катеринг” ХХК-д “Т07” код 17 тавцант вагоныг, “Баян мод трейд” ХХК-д 2022.02.17-ний өдрийн 53 тоотой “Т03” код, “Өмчлөгчийн код олгох тухай” 2022.02.22-ны өдрийн А/12 тушаалаар “Илинк Жэй Ви ложистик” ХХК-д “17”, 02.23-ний өдрийн А/15 тушаалаар “Шууд хур” ХХК-д “18”, А/16 тушаалаар “Монцемент билдинг материалс” ХХК-д “19”, 02.25-ны өдрийн А/17 “Моншике” ХХК “21”, 2022.03.01-ний өдрийн А/19 тоот тушаалаар “Монголиантранс лордс” ХХК-д “20”, 2022.03.07-ны өдрийн А/21 тоот тушаалаар “Монголиан транс ложистик” ХХК-д 22 кодыг олгож мэдээллийн санд бүртгэсэн.

“УБТЗ” ХНН-д 2022.02.11-ний өдрийн 47 тоот 200 тавцант, 02.16-ны өдрийн 48 тоотой 300 хагас, 02.21-ний өдрийн 61 тоотой 200 тавцант вагоныг, 02.23-ний 67 тоотой 300 тавцант вагоныг, 2022.03.09-ний 87 тоотой 50 хагас вагоны дугаарын давхцалыг шалгуулан хариу албан бичиг хүлээн авсан.

2021 оны хөдлөх бүрэлдэхүүнд шинээр код болон дугаар олгосон, төвийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хийсэн тухай хуулийн этгээдийн албан хүсэлт, баримт бичиг, хавсралт материалыг бэлтгэн 3200 гаруй хуудас бүхий 16 боть архивын материалыг архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.

2022.03.11-ний 93 тоотой төмөр замын салбарын 16 байгууллагад, 03.14-ний 97 тоотой “БАГАНУУР” ХХК-д, 03.15-ны 98 тоотой “ЦЕМЕНТ ШОХОЙ” ХХК-д өөрийн эзэмшлийн ачааны вагоны дэлгэрэнгүй судлагааг хүргүүлэх тухай албан бичгийг цахимаар хүргүүлсэн. 03.11-18 өдрүүдэд 19 байгууллагуудаас судалгааг албан бичгээр болон цахим хэлбэрээр хүлээн авч нэгтгэн боловсруулсан.

2022.02.18-ны өдрийн 54 тоотой хөдлөх бүрэлдэхүүний 2022.02.01-ний өдрийг хүртлэх тайлан мэдээг, 02.25-ны өдрийн 69 тоотой ашиглалтын хугацаа дууссан хөдлөх бүрэлдэхүүний мэдээллийг ЗТХЯ-ны ХШУДАГ-т хүргүүлсэн.

“Моншеки” ХХК-аас ирүүлсэн 2022.02.24-ний 2/24 дугаартай болон “Баясон ложистик” ХХК-ийн 25-ны 22/04 дугаартай албан хүсэлтийг судлан 2022.02.25-ны өдрийн 73 тоотой “Баясон ложистик” ХХК-ийн 100 тавцант вагоныг “Моншеки” ХХК-ийн нэрд шилжүүлэн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.